



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/251/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга, аудитын менежер Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер Я.Алтанцэцэг Утас: 325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn Ахлах аудитор: М.Ундармаа Утас: 325093 Цахим хаяг: undarmaam@audit.gov.mn Аудитор: Л.Энх-Амгалан Утас: 325093 Цахим хаяг: enkhambalanl@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.02.23 № 101
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН ДАГУУЛ ХОТ,
ЭДИЙН ЗАСГИЙН ТУСГАЙ
БҮСИЙН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ, ТӨСВИЙН
ШУУД ЗАХИРАГЧ А.МӨНГӨН
ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Нийслэлийн Дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн бөгөөд Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, 6 дугаар зүйлийн 6.4.1 заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

Төсөл боловсруулах ажлын хүрээнд 62,500.0 мянган төгрөгөөр видео танилцуулга хийлгэж төсвийг үр ашиггүй зарцуулсан.

Дуудлагын автомашин хэрэглэхдээ илүү цагаар ажиллуулсны төлбөрт 4,306.0 мянган төгрөгийг зарцуулж, төсвийг үрэлгэн зарцуулсан.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад нэмэлт

D:\Desktop\2024\Word\Review\Banan\2024.02.23\Daгуул хот.101.docx

002021844

санхүүжилтийн орлогоор худалдаж авсан бараа материалыг эд хариуцагчаар дамжуулаагүй, шууд зардлаар бүртгэснээс бусад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус хэлтсийн талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын 19 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 96.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

D:\Desktop\2024\Work\Report\2024.02.22\Org.aud.html.docx

Хоёр.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>13,136,200.00</u>	<u>94,203,980.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	13,136,200.00	94,203,980.00
351	Түүхий эд материал	8,000,000.00	88,500,000.00
35110	Тусгай зориулалттай материал	8,000,000.00	88,500,000.00
354	Хангамжийн материал	5,136,200.00	5,703,980.00
35410	Бичиг хэргийн материал	1,861,200.00	1,798,400.00
35470	Бусад хангамжийн материал	3,275,000.00	3,905,580.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>120,655,799.93</u>	<u>128,369,268.35</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	120,655,799.93	128,369,268.35
392	Биет хөрөнгө	112,263,799.94	121,753,268.36
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	66,031,000.00	103,450,800.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-7,837,500.00	-31,043,239.81
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	57,178,000.00	59,268,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,107,700.06	-9,922,291.83
393	Биет бус хөрөнгө	8,391,999.99	6,615,999.99
39301	Програм хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-88,000.02	-264,000.06
39303	Бусад биет бус хөрөнгө	8,000,000.00	8,000,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-399,999.99	-1,999,999.95
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>133,791,999.93</u>	<u>222,573,248.35</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>330,000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	330,000.00
413	Өглөг	-	330,000.00
4136	Бусад өглөг	-	330,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	330,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>133,791,999.93</u>	<u>222,243,248.35</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	133,791,999.93	222,243,248.35
512	Хуримтлагдсан үр дүн	133,791,999.93	222,243,248.35
51210	Өмнөх үеийн үр дүн	133,791,999.93	133,791,999.93
51220	Тайлант үеийн үр дүн	-	88,451,248.42
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>133,791,999.93</u>	<u>222,573,248.35</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	500,000,000.00	648,856,065.08

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	500,000,000.00	648,856,065.08
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	500,000,000.00	648,856,065.08
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	500,000,000.00	648,856,065.08
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	366,208,000.07	560,404,816.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	366,208,000.07	560,404,816.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	315,568,505.90	555,404,816.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	188,039,631.71	406,498,043.53
210101	Үндсэн цалин	133,873,413.43	236,760,576.60
210102	Нэмэгдэл	26,186,308.13	80,874,854.55
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,248,998.75	40,118,496.73
210104	Урамшуулал	13,730,911.40	48,744,115.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,103,459.13	50,531,173.55
210201	Тэтгэврийн даатгал	15,960,155.96	34,934,288.31
210202	Тэтгэмжийн даатгал	1,877,664.89	4,109,914.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,502,131.95	3,287,933.28
210204	Ажилгүйдлийн даатгал	330,358.68	732,438.03
210205	Эрүүл мэндийн даатгал	3,433,147.65	7,466,599.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	6,419,547.00
210304	Байрны түрээс	-	6,419,547.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,502,300.99	39,825,721.00
210401	Бичиг хэрэг	5,392,520.00	7,512,770.00
210402	Тээвэр, шатахуун	12,000,000.00	20,891,510.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,433,880.99	9,812,041.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	675,900.00	1,609,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,928,800.00	-
210604	Урсгал засвар	29,928,800.00	-
2107	Томилолт, зочны зардал	-	1,384,000.00
210702	Дотоод албан томилолт	-	1,384,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,700,000.00	550,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,700,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	550,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,294,314.07	50,196,331.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,861,114.00	18,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	400,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,433,200.07	31,796,331.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,639,494.17	5,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	5,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	5,000,000.00

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	50,439,494.17	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	50,439,494.17	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>133,791,999.93</u>	<u>88,451,248.42</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>133,791,999.93</u>	<u>88,451,248.42</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>500,000,000.00</u>	<u>648,856,065.08</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	500,000,000.00	648,856,065.08
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	500,000,000.00	648,856,065.08
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	500,000,000.00	648,856,065.08
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>367,911,000.00</u>	<u>609,346,265.08</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	367,911,000.00	609,346,265.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	317,271,505.83	604,346,265.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	188,039,631.71	406,168,043.53
210101	Үндсэн цалин	133,873,413.43	236,430,576.60
210102	Нэмэгдэл	26,186,308.13	80,874,854.55
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,248,998.75	40,118,496.73
210104	Урамшуулал	13,730,911.40	48,744,115.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,103,459.13	50,531,173.55
210201	Тэтгэврийн даатгал	15,960,155.96	34,934,288.31
210202	Тэтгэмжийн даатгал	1,877,664.89	4,109,914.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,502,131.95	3,287,933.28
210204	Ажилгүйдлийн даатгал	330,358.68	732,438.03
210205	Эрүүл мэндийн даатгал	3,433,147.65	7,466,599.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	6,419,547.00
210304	Байрны түрээс	-	6,419,547.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,897,000.99	39,963,501.00
210401	Бичиг хэрэг	6,985,720.00	7,366,650.00
210402	Тээвэр, шатахуун	12,000,000.00	20,891,510.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,016,380.99	9,812,041.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,894,900.00	1,893,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,483,800.00	430,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	430,000.00
210602	Тавилга	555,000.00	-

210604	Урсгал засвар	29,928,800.00	-
2107	Томилолт, зочны зардал	-	1,384,000.00
210702	Дотоод албан томилолт	-	1,384,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,244,500.00	63,050,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,700,000.00	62,500,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	544,500.00	550,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,503,114.00	36,400,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,503,114.00	36,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	400,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,639,494.17	5,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	5,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	5,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	50,439,494.17	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	50,439,494.17	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>132,089,000.00</u>	<u>39,509,800.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	132,089,000.00	39,509,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	132,089,000.00	39,509,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	132,089,000.00	39,509,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	132,089,000.00	39,509,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(132,089,000.00)</u>	<u>(39,509,800.00)</u>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	133,791,999.93	133,791,999.93
C08	2022оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	133,791,999.93	133,791,999.93

D01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	-	-	133,791,999.93	133,791,999.93
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	133,791,999.93	133,791,999.93
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	88,451,248.42	88,451,248.42
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	222,243,248.35	222,243,248.35

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тоо	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	671,480,200.00	648,856,065.08	(22,624,134.9)	96.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	671,480,200.00	648,856,065.08	(22,624,134.9)	96.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	666,480,200.00	643,856,065.08	(22,624,134.9)	96.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	417,346,100.00	406,168,043.53	(11,178,056.5)	97.3
210101	Үндсэн цалин	255,825,900.00	236,430,576.60	(19,395,323.4)	92.4
210102	Нэмэгдэл	77,228,200.00	80,874,854.55	3,646,654.6	104.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	44,880,000.00	40,118,496.73	(4,761,503.3)	89.4
210104	Урамшуулал	39,412,000.00	48,744,115.65	9,332,115.7	123.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,983,200.00	50,531,173.55	(9,452,026.5)	84.2
210201	Тэтгэврийн даатгал	40,788,600.00	34,934,288.31	(5,854,311.7)	85.6
210202	Тэтгэмжийн даатгал	4,798,700.00	4,109,914.70	(688,785.3)	85.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,838,900.00	3,287,933.28	(550,966.7)	85.6
210204	Ажилгүйдлийн даатгал	959,700.00	732,438.03	(227,262.0)	76.3
210205	Эрүүл мэндийн даатгал	9,597,300.00	7,466,599.23	(2,130,700.8)	77.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,919,900.00	6,419,547.00	(500,353.0)	92.8
210304	Байрны түрээс	6,919,900.00	6,419,547.00	(500,353.0)	92.8

2104	Хангамж, бараа материалын зардал	41,591,000.00	40,403,501.00	(1,187,499.0)	97.1
210401	Бичиг хэрэг	7,000,000.00	7,366,650.00	366,650.0	105.2
210402	Тээвэр, шатахуун	21,567,000.00	20,891,510.00	(675,490.0)	96.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,944,000.00	9,812,041.00	(1,131,959.0)	89.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,080,000.00	2,333,300.00	253,300.0	112.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	39,500,000.00	39,499,800.00	(200.0)	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	39,500,000.00	39,499,800.00	(200.0)	100.0
2107	Томилолт, зочны зардал	1,420,000.00	1,384,000.00	(36,000.0)	97.5
210702	Дотоод албан томилолт	1,420,000.00	1,384,000.00	(36,000.0)	97.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	63,320,000.00	63,050,000.00	(270,000.0)	99.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	62,520,000.00	62,500,000.00	(20,000.0)	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	800,000.00	550,000.00	(250,000.0)	68.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,400,000.00	36,400,000.00	-	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,000,000.00	36,000,000.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400,000.00	400,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,000,000.00	5,000,000.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,000,000.00	5,000,000.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	5,000,000.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	671,480,200.00	648,856,065.08	(22,624,134.9)	96.6
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	671,480,200.00	648,856,065.08	(22,624,134.9)	96.6
132001	Орон нутгийн төсвөөс	671,480,200.00	648,856,065.08	(22,624,134.9)	96.6
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	20	20	-	100
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.
620002	Гүйцэтгэх ажилтан	19	19	-	100.

3

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 13,021.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Залруулсан алдаа:

- Санхүүгийн тайлангуудын зардлыг 12,691.9 мянган төгрөгөөр нэр данс зөрүү бүртгэж илүү тайлагнасан. Энэ нь УСНББОУС-20 холбоотой талуудын тодруулга, УСНББОУС-24 төсвийн мэдээллийн толилуулга болон санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “толилуулга” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
- Ажилтны цалингаас суутган Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба болон банкны өр барагдуулах албанд төвлөрүүлэх дүнг дутуу төлж 330.0 мянган төгрөгөөр өглөгийг дутуу илэрхийлсэн. Энэ нь УСНББОУС-20 холбоотой талуудын тодруулга, “Үнэлгээ ба хуваарилалт”, “толилуулга” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 106,813.8 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд 4 зөвлөмж өгсөн.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нийт зардал данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Төсөл боловсруулах ажлын хүрээнд 62,500.0 мянган төгрөгөөр видео танилцуулга хийлгэж төсвийг үр ашиггүй зарцуулсан нь төсвийг хяналтгүй зарцуулах үр дагаврыг бий болгож байна. Энэ Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “Хариуцлагатай байх” 6 дугаар зүйлийн 6.4.1 төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;” заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Ажлын даалгавартай уялдуулан төсөл боловсруулахад зарцуулсан хөрөнгийн үр ашгийг дээшлүүлж байх зөвлөмж өгөх.

2. Нийт зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Дуудлагын авто машин хэрэглэхдээ илүү цагаар ажиллуулж 4,306.0 мянган төгрөгийг үр ашиггүй зарцуулсан нь төсөв хяналтгүй зарцуулагдах үр дагавар бий болгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “Хариуцлагатай байх” 6 дугаар зүйлийн 6.4.1 төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;” заалтыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Дуудлагын автомашин хэрэглэхдээ үр ашиггүй зардал гаргахгүй байх талаар төсвийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлж байх зөвлөмж өгөх.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Нийт зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Томилолтоор ажиллах үеийн 2 өдөр байрласан байрны нэр хаяг тодорхой бус, и-баримтаар баталгаажуулаагүй 498.0 мянган төгрөгийн зардал гаргасан нь төсөв хяналтгүй зарцуулагдах үр дагавар бий болгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*” заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Бараа, ажил үйлчилгээний худалдан авалтыг хийхдээ татварын цахим системд бүртгэгдсэн баримтыг үндэслэн ажил, гүйлгээг бүртгэж байх зөвлөмж өгөх.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангуудын зардлын нэр данс зөрүү бүртгэж тайлагнасан	1	12,691.9			1	12,691.9	1	12,691.9				
Ажилтны цалингаас суутган Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба болон банкны өр барагдуулах албанд төвлөрүүлэх дүнг дутуу төлж, зөрүүг өглөгөөр тайлагнаагүй	1	330.0			1	330.0	1	330.0				
Дүн	2	13,021.9	-	-	2	13,021.9	2	13,021.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	/мянган төгрөгөөр/ Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсөл боловсруулах ажлын хүрээнд видео танилцуулга хийлгэж төсвийг үр ашиггүй зарцуулсан	1	62,500.0					1	62,500.0				
Томилолтоор ажиллах үеийн 2 өдөр байрласан байрны нэр хаяг тодорхой бус, и-баримтаар баталгаажуулаагүй.	1	498.0					1	498.0				
Дуудлагын авто машин хэрэглэхдээ илүү цагаар ажиллуулж төсвийг үр ашиггүй зарцуулсан	1	4,306.0					1	4,306.0				
Дүн	3	67,304.0			0	0	3	67,304.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Төрийн хэмнэлтийн хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй	1	39,509.8						1	39,509.8
Нийт дүн	1	39,509.8						1	39,509.8